



НИЙСЛЭЛИЙН
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл
сунгах, шинээр олгох, нэр шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрээс хол зайд байрлаж, худалдааны газрын стандартын шаардлагыг хангасан, тамхи худалдах зөвшөөрөл шинээр олгох иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг нэгдүгээр, зөвшөөрлийн хугацааг сунгах иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Л.Саруултуяа)-т, хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газар (хурандаа Т.Дамбийням)-т, хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Б.ЦЭРЭН



1726010062

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2024 оны 01 дүгээр сарын
15-ны өдрийн 1119 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

ТАМХИ ХУДАЛДАХ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ
ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Регистрийн дугаар	Оноосон нэр	Хаяг, байршил	Үйлчилгээний чиглэл	Захирал, эзний нэр, утас	ТЗ-ийн дугаар
1	Хан хур хангай ХХК	8428158	Төгс	ХУД 21-р хороо төгс орчин хотхон 286г байр 1 давхар	Хүнсний дэлгүүр	Б.Олонгэрэл	2024/01

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2024 оны 07 дугаар сарын
18-ны өдрийн 1179 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ТАМХИ ХУДАЛДАХ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН
НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Регистрийн дугаар	Оноосон нэр	Хаяг, байршил	Үйлчилгээний чиглэл	Захирал, эзний нэр, утас	T3-ийн дугаар
1	Наадам grosери ХХК	6482902	Наадам маркет	ХУД 15-р хороо Цэнгэлдэх хотхон 207-р байр 1 тоот	Хүнсний дэлгүүр	Л.Лечинханд	2024/02
2	Эрдэнэ хашаат ХХК	5343704	Мөнх аривжих	ХУД 9-р хороо 19-р гудамж 656 тоот	Хүнсний дэлгүүр	Т.Алтанцэцэг	2024/03
3	Мөст Уул ХХК	2145375	Мөнхийн Рашаан	ХУД 5-р хороо 15-360 тоот	Хүнсний дэлгүүр	Ц.Хөхөөбат	2024/04
4	Чандмань гишгэр ХХК	6634559	8 нэрийн дэлгүүр	ХУД 11-р хороо Ар зайсан гудамж 95-1 тоот	Хүнсний дэлгүүр	Л.Цэндсүрэн	2024/05
5	Ундрам дэвших заяа ХХК	6593593	Заяа маркет	ХУД 20-р хороо үйлдвэр чингисийн өргөн чөлөө 94В байр Ү тоот	Хүнсний дэлгүүр	Б.Билэгсайхан	2024/06
6	Ерөөлт интернэшнл ХХК	2581558	8 нэрийн дэлгүүр	ХУД 20-р хороо ЧӨЧ 143/11 тоот	Хүнсний дэлгүүр	Г.Ганболд	2024/07